

© The Financial Times Limited (2015). All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

Торгоны замд Австрали нэгдэхгүй

Вашингтоны дэмжлэгийг хүссэн энэ үед Америк, Австралийн харилцаанд сэв суулгана хэмээн үзжээ. > 10

Тансаг бүтээгдэхүүний зах зээлийн хүнд үе ард үлдэв

"Хангалттай инноваци нэвтрээгүй ч бүтээгдэхүүний үнэ маш их өссөн. Өөртөө хэт бардахын аюул гэж бий". > 10



Шинэ дугаар ХУДАЛДААНД ГАРЛАА!
+976 77074646


Вестминстерт болсон террорист халдлага

◀
Ниццад өнгөрсөн онд ачааны машинтай этгээд явган хүмүүс рүү дайрч, 84 хүний амийг хөнөөсөн халдлагатай энэхүү хэрэг төстэй. Хууль сахиулагчид уг хэргийг “исламистуудтай холбоо бүхий олон улсын терроризмын сэдэлтэй” хэмээн таамаглаж байгааг Метрополитен цагдаагийн албаны орлогч комиссар Марк Роули лхагва гарагийн орой мэдэгдсэн. Цагдаагийн байгууллага халдлага үйлдэгч хэн болохыг мэдэж байгаа ч хамсаатнуудыг нь мөрдөн хайхад дөхөм болох үүднээс тодорхой мэдээллэл өгөхөөс түдгэлзэж байгааг ноён Роули тайлбарлав.

Халдлагд ортож, амь үрэгдсэн цагдаа, парламентын хамгаалалтын багийн зэвсэггүй ажилтан, 48 настай Кит Палмер нь Метрополитен цагдаагийн албанд 15 жил ажилласан туршлагатай, эр нөхөр, эцэг хүн байсныг комиссар мөн мэдээллээ. Вестминстерт болсон террорист дайралтын дараа, СОBRA буюу Засгийн газрын аюулгүйн тусгай хороо хуралдаж, Даунинг стритээс эргэн ирсэн хагатай Мэй нийслэл хотын зүрхэн тушаа газарт үйлдсэн бузар террорист дайралтыг яллан зэмлэв.

“Халдлагад өртөж, амь үрэгдэгчид болон хайртай дотно хүмүүсээ эргэн ирэхийг нь хүлээх аргагүй болсон ар гэр, анд

Халдлага үйлдэгчид эмнэлгийн тусламж үзүүлэх үед хоёр хутга газарт хэвээр байж байлаа.



BBM©

нөхдөд нь эмгэнэл илэрхийлж залбирья” хэмээн хатагтай Мэй өгүүллээ. Тэрбээр мөн “бусдыг холдуулж зайлуулангаа аюулын зүг өрсөн гүйдэж байсан хууль сахиулах албаны эрлэхэг эрчүүд, эмэгтэйчүүдийг сайшаасан юм. “Бид бүхнийг нэг нэгээс нь хөндийрүүлж, бусдыг үзэн ядахыг уриалагч дуу хоолойд хэзээ ч боломж олгохгүйгээр, терроризмд бууж өгөлгүй,

хамтаар урагшилла” хэмээн Ерөнхий сайд мэдэгдэв.

Террорист халдлагыг зэмлэн буруутгаж буй Ерөнхийлөгч Дональд Трамп хатагтай Мэйтэй утсаар холбогдож ярилцсан талаар Цагаан ордны хэвлэлийн төлөөлөгч Шон Спайсер Вашингтонд сэтгүүлчдэд тайлбарласан. Германы канцлер Ангела Меркель “Терроризмын бүхий л хэлбэрийн эсрэг тэмцэлд

Британийн талд зогсох болно” хэмээн мэдэгдэв. Францын Ерөнхий сайд Бернар Казнэв мөн Их Британитай эв санааны нэгдэлтэй байгаагаа илэрхийлж байна.

Үдээс хойш гурван цагийн орчимд алан хядагчийн жолоодсон 4x4 автомашин Вестминстерийн гүүрээр явган хүмүүсийг дайрсаар Биг Бен цамхаг чиглэсэнээр халдлага эхэлжээ. Уг газар орчин ихэвчлэн

жуулчдаар дүүрэн байдаг юм. Машин Вестминстер ордны гол үүдний ойролцоох хашаа мөргөж зогмогч халдлага үйлдэгч бууж, хаалгаар нэвтрэхийн тулд дотор талбай руу тойрон гүйжээ.

Хоёр хутгаар зэвсэглэсэн, дунд эргэм насны уг этгээд цагдааг нуруунаас нь дараалан хутгалмагц өөр нэг цагдаа буудаж хөнөөсөн ажээ. Их Британийн аюулгүйн алба

сүүлийн дөрвөн жилд 13 болзошгүй халдлагаас сэргийлж чадсангыг Засгийн газар саяхан мэдэгдсэн. Британийн терроризмтэй тэмцэх байгууллага нэг дор 500 орчим хэрэг байнга мөрдөж байдаг. Уг хэрэгт холбогдох гэрэл зураг, дүрс бичлэг ирүүлэхийг тус улсын цагдаагийн алба иргэдээс хүсээд байгаа юм.



Хуучин туслахын бизнес Ерөнхийлөгчийн нэр хүндэд сэвтэй

Хэнри Фой, Деметри Севастополю

Дональд Трампын сонгуулийн кампанийг удирдаж байсан Пол Манафорт болоод ОХУ-ын тэрбумтны хооронд байгуулсан бизнесийн гэрээ АНУ-ын Ерөнхийлөгчөөс Москвагай тогтоосон харилцааг түвэгтэй байдал оруулж болзошгүй боллоо.

Ноён Манафорт ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путиний ашиг сонирхлыг хамгаалахаар холслөгдөн тухай тайлан саяхан нийтлэгдсэн. ОХУ-ын хамгийн баян эрхмийн нэг, аж үйлдвэрийн магнат Олег Дерипаска түүнийг Путиний Засгийн газарт асар их ач тустай үйл ажиллагаа эрхлүүлэхийн тулд холслосон тухай Associated Press агентлаг нийтэд задарсан баримтад тулгуурлан мэдээлжээ. Ноён Трампын сонгуулийн

кампанийн удирдагч, ОХУ-ын албаны хүмүүсийн хоорондох хэлхээ холбоог мөрдөн шалгаж байгаа талаар Холбооны мөрдөх товчооны захирал Жэймс Коми мэдэгдсэнээс хойш хоёрхон хоногийн дараа уг тайлан гарчээ. Уг шалгалт АНУ-ын сонгуульд Кремль хөндлөнгөөс оролцсон, эсэхийг мөрдөн шалгах ажиллагааны хүрээнд болж байгаа юм. Уг мөрдөн шалгах ажиллагаанд Ардчилсан намын Үндэсний хорооны цахим сулжээнд хууль бусаар нэвтэрсэн хэрэг ч хамаатай.

ОХУ-тай тогтоосон харилцаа нь ноён Трампыг 2015 онд Ерөнхийлөгчийн сонгуулийн кампаниа эхэлсэн үеэс хойш байнга түвэг учруулж ирлээ. АНУ-ын шинэ Ерөнхийлөгч Владимир Путинийг шүүмж-

лэхээс татгалздаг нь хов жив, цуурхал дэгдэх шалтаг болоод зогсохгүй Ардчилсан болон Бүгд найрамдах намтай тогтоосон харилцаанд нь ч будлиан үүсгэдэг.

Ноён Дерипаска ОХУ-ын Ерөнхийлөгчийн ашиг сонирхолд үйлчлүүлэхийн тулд ноён Манафортыг холслосон эсэхийг асуухад орос тэрбумтны төлөөлөгч тайлбар өгөхөөс татгалзсан юм. “Дерипаскагийн бизнесийн ашиг сонирхолд хамаатай хөрөнгө оруулалтын зөвлөгөөний үйлчилгээ авах тухай ноён Манафорт, Дерипаска нарын хооронд байгуулсан гэрээ нь хууль зүйн хувьд хэрэг үүсгэх шалтгаан болоод байгаа”-г орос тэрбумтны хэвлэлийн төлөөлөгч өгүүлж байна.

Ноён Дерипаска 2006 онд

жил тутам 10 сая ам.доллар төлөх нөхцөлтэйгөөр ноён Манафорттой гэрээ байгуулж, улмаар уг бизнесийн харилцаа лавтайяа 2009 он хүртэл үргэлжилснийг AP агентлаг тайлбарласан. Ойролцоогоор таван тэрбум ам.долларын хөрөнгөтэй ноён Дерипаскагийн “Базовый элемент” конгломерат группт “Русал” хэмээх хэмжээгээрээ дэлхийд хоёрдугаарт ордог хөнгөн цагааны компани, нисэх онгоц, ачааны машины үйлдвэр, даатгалын компани, нисэх онгоцны таван буудал харьяалагддаг.

Украин дахь ОХУ-ын тал баримтлагчдад үйлчилж ирсэн ноён Манафорт өнгөрсөн сард FT-д өгсөн ярилцлагадаа “Путиний цагаг захиргаатай ямар ч хэлхээ холбоо байхгүй”

хэмээн тайлбарласан. Тэрбээр АНУ-ын Ерөнхийлөгчийн 2016 оны сонгуульд ОХУ-ын тагнуулын албад оролцсон тухай сэжгийг эрс няцаав. “Хоёр бизнесмений хооронд хувийн болоод бизнесийн хэлхээ холбоо үнэхээр бий” хэмээн ноён Манафорттой Украинд хамт ажиллаж явсан нэгэн өгүүллээ. Уг эрхэм ноён Дерипаскагийн зорилго Владимир Путинд туслахтай хамаагүй л болов уу хэмээн таамаглаж байна.

Тайлбар авах хүсэлтэд АНУ-ын Ерөнхийлөгчийн хэвлэлийн төлөөлөгч “Цагаан ордонд ажилладаггүй хүний талаар тайлбар хэлэхийг бид зохисгүй гэж үзэж байна” хэмээн хариуллаа.

Өөрийнх нь туслах байсан хүнийг ОХУ-тай холбон

буруутгаж буй бүх хов жив нь “Хуурамч, зохиомол мэдээллийн жишээ болж чадна” хэмээн ноён Трамп үзэж байна. Тангараг өргөснөөсө хойш ч ноён Трамп ОХУ-тай холбоотой хэл амнаас салахгүй байгаа. Ерөнхийлөгчийн Үндэсний аюулгүй байдлын анхны зорилго Майкл Флинн ОХУ-ын Элчин сайд Сергей Кисляктай ярилцсан ярианыхаа агуулгыг гүйвуулснаасаа болж албанаасаа огцроход хүрсэн. Ноён Флиннийг ОХУ-ын төрийн мэдээллийн групп RT-ээс мөнгө авсан, ОХУ-ын удирдагчаас суртал ухуулгын хэрэглүүр болгон зохиосон дайллага дээр ноён Путинтэй зэрэгцээ суудалд суусан зэргээр урьд нь шүүмжилж байв.



ДНХ-ийн код тайлахад хагас сая британичуудыг хамруулна

Клайв Куkson

Төрийн мэдлийн UK Biobank судалгааны байгууллагаас GlaxoSmithKline, Regeneron эмийн компаниудтай хамтран 120 сая фунт стерлингийн өртгөөр явуулж буй судалгааны хүрээнд Их Британийн 500 мянган иргэний ДНХ-ийн кодыг тайлах гэж байна.

Дөрвөн жил үргэлжлэх судалгааны явцад Biobank-д сайн дураар хандивлагчдаас авах цусны 500 мянган дээжээс генийн өгөгдөл цуглуулж, хүний эрүүл мэнд, амьдралын дадал заншилтай холбоотой биохими, генийн үзүүлэлтийг харьцуулан судлах юм. Дэлхийн эрдэмтэн судлаачид өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэхтэй холбоотой нарийн судалгаанд чухал үүрэгтэй.

манай гараг дээрх эрүүл мэндийн хамгийн иж бүрэн эх сурвалж, Biobank ашиглах явдлыг идэвхтэй дэмждэг боллоо. Тус байгууллага нь Их Британийн Засгийн газар, анагаах ухааны хандивын сангуудаас 200 сая фунт стерлингийн хөрөнгө цуглуулаад байна.

“UK Bio Bank нь эрүүл мэнд, амьдралын хэв төрх, анагаах болон биологийн ухаантай холбоотой, найдвартай хадгалалт бүхий асар их өгөгдөлтэй”-г Biobank-ийн удирдагч Сэр Рори Коллинз тайлбарлав. Тэрбээр “Энэ сайхан төслийн ачаар шинэ шинэ нээлт, дүгнэлт шууд энэ оноос гарч эхэлнэ” хэмээн өгүүлж байна

Эмийн компаниуд илүү үр дүнтэй бүтээгдэхүүн хөгжүүлж бүтээх гэвэл хүний

генийн мэдээллийг цуглуулах шаардлагатай талаар Сэр Рори тайлбарласан юм. Клиник туршилтаар оруулж буй байгууллага болзошгүй эмийн 90 хувь нь зах зээлд гаргах боломжгүй, үр дүн муутай, аюултай эд байдаг. Шалтгаан нь эмийн биологийн зориулалт болоод хүний өвчний хоорондох хамаарлыг харуулдаг генийн баримт материал дутагддаг болон үүдсэн буруу ойлголт төсөөлөл.

Их Британийн эмийн тэргүүлэх үйлдвэрлэгч GSK, АНУ-ын биотехнологийн аварга - Regeneron компани хамтран ДНХ-ийн төслийн эхний шатыг хэрэгжүүлэхэд 12 сая фунт стерлингийн суурь хөрөнгө оруулалт хийжээ. Уг шатанд цуглуулсан 50 мянган дээжийг геномын дараалал тайлах ажлаар

төрөлжсөн дэлхийн хамгийн том лаборатори-Нью Йоркийн Хадсоны хөндий дэх Regeneron-ий Генетикийн төвд энэ онд багтаан илгээж, дарааллыг нь тайлах юм.

Biobank-ийг үүсгэн байгуулахад баримталсан, судалгааны эх үүсвэрийг нийтэд хүртээмжтэй, нээлттэй байлгах зарчимд нийцүүлэн, зөвхөн дээрх хоёр компани харьцангуй үүдсэн буруу ердөө есөн сарын хугацаанд ДНХ-ийн сантай харьцах онцгой эрх эдэлнэ. Заасан хугацаа дуусмагц уг сан шинжлэх ухааны илүү өргөн хүрээнд нээлттэй болох юм.

Энэхүү төсөл нь цусны дээж авсан хүн бүрийн ехот-ийн дарааллыг тайлах ажллагаагаар эхэлнэ. Ехот нь биологийн ажиллагааны үндсэн молекул,

уурганд кодлогддог ген юм. Дараа нь хүний эсийн бөөмөнд оршдог ДНХ-ийн бүрдлийг унших замаар генийн үйл ажиллагааг хянагч хэсгийг оролцуулаад, геномын дарааллыг бүрэн тайлахад шилжиж болзошгүй.

Regeneron-ий ахлах эрдэмтэн Жорж Янкопулос Biobank-ийг “Хүсээд олддоггүй боломж” хэмээн тодорхойлж байв. Тэрбээр Их Британийн NHS буюу Үндэсний эрүүлийг хамгаалах албаны цогц бүтцийн ачаар генийн өгөгдлийг тухайн өвчтөний өвчний түүхтэй хялбар холбодог нь АНУ-д хэрэгжүүлж буй ижил төрлийн хөтөлбөрөөс давуу талтай болгож байгааг тайлбарлав. АНУ-д өвчтөний өвчний түүх нь даатгалын янз бүр компани, төрийн эрүүл

мэндийн төрөл бүрийн сангуудад тархай байдаг тул өвчтөн өөр өөр эмнэлэг дамжих хэрээр шилжиж явдаг.

Biobank-ийн төсөл нь “Их Британи инновацилаг судалгааны төв болох нь хэчнээн чухлыг харуулж өглөө” хэмээн Засгийн газрын удирдагч Патрик Валланс тайлбарлав.

Эмийн үйлдвэрлэл эрхлэгч компаниуд геномын өгөгдлийн сантай харьцах боломжийг эрэлхийлсээр. Жишээ нь, өнгөрсөн онд AstraZeneca компани геномын ухааныг үүсгэгчдийн нэг Крег Вентерийн эрхэлдэг АНУ-ын Human Longevity Inc болон Кэмбрижийн Wellcome Trust Sanger Institute-тэй хамтран ажиллахаар болсноо зарласан.



Тансаг бүтээгдэхүүний зах зээлийн хүнд үе ард үлдэв

Ральф Аткинс

Баргар нэгэн жилийг үдсэний дараа тансаг цаг, үнэт эдлэлийн зах зээлд сэргэлтийн найдвар тээсэн оч хаяж эхэллээ. Пүрэв гарагт нээсэн Baselworld шоунаас швейцарь цагны зах зээлийн төлөв байдлын талаар Ральф Аткинс тоймлон хүргэж байна. Тэрбээр маш сайн хийсэн цагны эд анги, үнэт эдлэлийн борлуулалт идэвхжиж эхэлсэн нь дэлхийн хамгийн том брэндүүд дахин өсөхийг илэрхийлнэ хэмээн дүгнэсэн байна.

Энэ салбарынхан 2016 оныг мартсан нь дээр. Швейцарь цаг үйлдвэрлэлийн холбооны хэлж буйгаар үнэт, тансаг эдлэлийн зах зээлийн барометр болдог швейцарь цагны экспорт 2016 онд өмнөх жилийнхээс бараг 10 хувиар багасчээ.

Дэлхийн эдийн засгийн өсөлт саарч, Европыг зорих хятад жуулчдын тоо тэвдэл төрүүлэм цөөрөн, террорист халдлагаас үүдсэн айдас хийгээд Brexit-ийн улмаас фунт стерлингийн ханш суларсан зэрэг нь дэлхийн

Швейцарь цагны хамгийн том цор ганц зах зээл болон үлдсэн Хонконгод нөөц бууруулах арга хэмжээ амжилттай хэрэгжиж байна.



Торгоны замд Австрали нэгдэхгүй



Канберра Вашингтоныг бүс нутаг дахь оролцоогоо нэмэгдүүлэхэд шахалт үзүүлэхийн зэрэгцээ Австрали руу чиглэсэн Хятадын хөрөнгө оруулалтын их урсгалд хатуу хяналт тавьж эхэлсэн.

Жэйми Смит

Шинэ Торгоны замын дэд бүтцийн хөрөнгө оруулалтын санд Канберра таван тэрбум австрали долларын хөрөнгө оруулалт хий гэх Бээжингийн тулгалтыг Канберра хүлээж авахгүй. Канберра Номхон далайн бүс нутагт Вашингтоны дэмжлэгийг хүссэн энэ үед Америк, Австралийн харилцаанд сөв суулгана хэмээн үзсэнээс эл шийдвэрийг гаргажээ.

Нэг бүс, нэг зам санаачилгын хүрээнд авто болон төмөр зам, усан боомтуудын дэд бүтцийн санхүүжилтэд дөрвөн их наяд ам.доллар төвлөрүүлэхээр Бээжин бүс нутгийн томоохон эдийн засагтай орнуудыг нэгдэхийг шахаж эхэлсэн.

Харин энэ долоо хоногт Хятадын Ерөнхий сайд Ли Кэчяны Австралид хийх айлчлалын үеэр Хойд Австралийн дэд бүтцийн байгууламжийн асуудлаар ямар ч гэрээ хэлэлцээр хийхгүй гэдгээ Канберра баталж хэлнэ гэдгээ илэрхийллээ. Австралийн албаныхан “Айлчлалын үеэр энэ талаар албан ёсны ямар ч санаам бичиг байгуулахгүй” хэмээх тайлбар өгсөн байна.

Ноён Ли Хятад, Австралийн харилцааны амаргүй үед айлчилж байна. Канберра Вашингтоныг бүс нутаг дахь оролцоогоо нэмэгдүүлэхэд шахалт үзүүлэхийн зэрэгцээ Австрали руу чиглэсэн Хятадын хөрөнгө оруулалтын их урсгалд хатуу хяналт тавьж эхэлсэн. Мөн дотоодын хоёр том компанийг

нь худалдан авах хятадуудын алхамд хаалт хийгээд байгаа билээ.

Австралийн Гадаад хэргийн сайд Жюли Бишоп өнгөрсөн долоо хоногт Азийн энх тайван, тогтвортой байдлыг сайжруулахын тулд АНУ-ын оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай гэж Трампын засаг захиргаанаас шаардсан юм. Хятагтай Бишоп Сингапурт хийсэн мэдэгдэлдээ “Ардчилсан нийгмийн үнэт чанар болсон одоогийн тогтолцоонд Хятад зэрэг ардчилсан бүс орнууд оролцвол хожих нь мэдээж” хэмээжээ.

Гэтэл энэ мэдэгдлийн эсрэг Хятад бүр ч үйтэн хариу барив. Хятадын Гадаад хэргийн дэд сайд Жэн Зигуан “Ирээдүйд Австралитай олон талбарт нөхөрлөнө гэж найдаж байна. Бас Австрали улс “Чи хожиж, би алдаж байна” гэх мэт өрөөсгөл ойлголтуудыг хөсөр хаяж биз ээ” хэмээн хэвлэлийнхэнд хэлжээ.

Нэг бүс, нэг зам санаачилгын дэд бүтцийн санд Австрали нэгдэх эсэх талаарх маргаан нь Канберра Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банкинд нэгдсэнтэй адил эргэлзээ төрүүлдэг. 2014 онд Австрали АНУ, Японы лоббид автаж, Хятадын тэргүүлсэн олон талт зээлдэгчдийн бүлэглэлд нэгдэхгүй гэж шийдэж байсан. Гэвч Их Британи болон барууны хэд хэдэн улс зэрэглэлээ үл тоож, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банкинд нэгдсэний

дараа Канберра ч мөн ижил үйлдэл хийсэн билээ.

Ер нь ч Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк болон Нэг бүс, нэг зам гэх санаачилга нь АНУ-ын эсрэг Хятадын нөлөөллийг тэлэх арга зам хэмээн Австралийн Батлан хамгаалах, аюулгүй байдлын байгууллага үздэг талаар Австралиас БНХАУ-д сууж байсан Онц хөндөгч Бүрэн эрхт Элчин сайд Жефф Раби учирлав. Одоогоор Австрали, Хятадын хоорондын бизнесийн зөвлөхөөр ажиллаж буй тэрбээр хоёр орны харилцааг үндэслэн хэрэгжүүлэхийн оронд үнэ цэнийн талаар хэтэрхий идеалист байр суурь баримтлах болсонтой холбоотой аж.

Ноён Ли Кэчян Австралид хийх айлчлалын төлөвлөгөөндөө Хятадын дарга Ши Жиньпин авлигын эсрэг кампанит ажлын үеэр эх орноосоо зугтсан хятадуудыг хүлээлгэн өгөх тухай гэрээг албан ёсоор батлахад Канберра тусгажээ.

Мөн Австралийн тэрбумтан Жэймс Паркерын эзэмшлийн Crown Resorts тоглоомын төвийн 14 ажилтны асуудлыг Канберра хөндөнө. Тэрбумтан Жэймс Паркер 14 ажилтан нь өнгөрөгч оны аравдугаар сард баригдсаны дараа Хятадад саатуулагдаж үлдсэн юм.

Үүнээс гадна Австрали үхрийн махан бүтээгдэхүүнээ Хятадын зах зээлд их хэмжээгээр гаргах боломж эрэлхийлж байгаа бөгөөд энэ хүрээнд хоёр орны худалдааны чөлөөт урсгалд саад тотгор болж буй техникийн асуудлуудыг шийдвэрлэхэд ажиллаж аж.

Австралийн компаниуд Шинэ торгоны замд нэгдэх сонирхол их байгаагаа илэрхийлсэн ба бизнесийн томчууд ч үүнийг дэмжиж, түргэтгэх үүднээс Нэг бүс, нэг зам зөвлөх үйлчилгээ ч үзүүлэх болжээ. Бас Австралийн хойд бүс нутгийн эрх баригчид ч үүнд нэгдэх арга зам эрэлхийлж буй. Хятадын дарга Ши Жиньпин 2014 онд Австралид айлчлах үеэрээ энэ санаачилгатай уялдуулан Дарвин хот Шинэ торгоны замын үйлчилгээний төв болох том боломж байгааг онцолсон түүхтэй.

Гэвч Хятад энэ бүсийн худалдааны гол зам, загас агнуурын бүс нутагт өөртөө хэт итгэлтэй үйл ажиллагаа явуулж буй нь Австралийг бүс нутгийн амбийцдаа хашир байх хэрэгтэйг харуулж буй. Хамгийн сүүлд л гэхэд Хятадын Landbridge компани Дарвин хотын боомтыг худалдаж авсны дараагаар Канберра гадаадын худалдан авалтыг хязгаарлаж эхлээд байна. Энэ нь Вашингтон Дарвин боомтын ойролцоох АНУ-ын армийн баазын талаарх оны аравдугаар сард баригдсаны дагуу хатуу хяналт тавьж эхэлсэн. Мөн дотоодын хоёр том компанийг

хамгийн нэр хүндтэй брэндийг сөхрүүлсэн гол шалтгаанууд.

Гэхдээ салхи эргэжээ. Нэгдүгээр сард тансаг бүтээгдэхүүний конгломерат болох LVMH-ээс эрхлэн гаргадаг Bulgari, TAG Heuer брэндийн үнэт эдлэлийн борлуулалт 2016 оны дөрөвдүгээр улиралд оны эхэн үетэй харьцуулахад найман хувиар өсчээ. Харин бүтэн жилээр нь авч үзвэл 2015 оныхоос таван хувиар тэлсэн байна.

Cartier, Vacheron Constantin болон Piaget брэндийн үйлдвэрлэгч Richemont-ийн борлуулалт, санхүүгийн төлөв ч хамгийн хүнд үе эцэс болсон гэдгийг илтгэж байна. Өнгөрсөн жил Richemont ажлын байраа танаж, нөөцөө барагдуулахын тулд бүтээгдэхүүнээ зах зээлээс эргүүлэн худалдан авч, тэр ч байтугай брэндийн нэрээ ч “аньж” байлаа.

Харин Женевт байрладаг Richemont группийн борлуулалт 2016 оны сүүлчийн гурван улиралд өмнөх оныхоос таван хувиар нэмэгдсэн аж. Ази, Номхон далайн зах зээл дэх борлуулалт 10 хувиар өссөний дийлэнх нь Хятад, Өмнөд Солонгосын худалдан авалтын үр дүн юм. Бас Их Британид жуулчдын худалдан авалт идэвхжсэнээр бүс нутгийн үзүүлэлтэд жин дарсан байна.

Тэгвэл Omega, Tissot брэнд болон өөрийн нэрээр нэрлэсэн хуванцар цагны эзэн компани болох Swatch-ийн борлуулалтын өсөлт 2017 онд ч эрүүл төлөвтэй байна. Гэвч Swatch хэтэрхий өөдрөг байгааг ажиглагчид анхааруулав. Хүнд хэцүү гэгдэх өнгөрсөн жил Swatch ажлын байраа цомхотгоогүй бөгөөд нөхцөл байдлыг түр зуурын шинжтэй гэж үзэж байсан билээ.

Хэрэв сэргэлт тогтвортой үргэлжилбэл швейцарь цагны экспорт ч өсөх нь гарцаагүй. Тэгэхдээ хэт хурдтай өсөх нь юу л бол. 2017 оны нэгдүгээр сарын байдлаар нэг жилийн хугацаанд цагны экспорт 6.2 хувиар хумигдсан нь уналтын хамгийн доод цэгт хүрээгүй ч байж мэдэхийг илтгэж буй. LVMH-ийн ТУЗ-ийн дарга Бернар Арно “2016 онд ажиглагдсан бага зэргийн сэргэлт нь геополитик, эдийн засгийн тогтворгүй байдалтай холбоотой” гэв. Тансаг бүтээгдэхүүний салбарт цаг нь ямагт үнэт эдлэлийн дараа ордог бүтээгдэхүүн гэж шинжээчид үздэг тул асуудал амаргүй байх нь тодорхой юм.

“Baselworld шоунд оролцох шинэ загваруудын хувьд өндөр үнэтэй, үнэт эдлэлтэй арай ойр гэдэг утгаар нь эмэгтэй цаг илүү сонирхол татах болов уу. Тэгээд ч үнэт эдлэлийн зах зээл цагтай харьцуулахад сайн байгаа” хэмээн Швейцарийн Vontobel арилжааны банкны шинжээч Рене Уэбер тайлбарлав.

Тэгвэл Citigroup-ийн тансаг бүтээгдэхүүний капиталын

судалгааны газрын тэргүүн Томас Шове “Энэ салбар харин ч дөнгөж хумигдах шатандаа ирж байна. Хэдийгээр тоон үзүүлэлтүүд тийм муу биш байгаа ч хөрөнгө оруулагчид хамгийн хүнд үедээ байгаа гэдэгт итгэхийг хүсээд байна шүү дээ. Өнгөрсөн 10 жилд хангалттай инноваци нэвтрээгүй хэдий ч бүтээгдэхүүний үнэ маш их өссөн. Өөртөө хэт бардахын аюул гэж бий. Эцсийн эцэст ухаалаг цаг үйлдвэрлэх нь швейцарь цаг үйлдвэрлэгчийн биш, харин технологийн компанийн хийх ажил шүү дээ” гэв.

Яг үнэндээ цаг үйлдвэрлэгчид хэрэглэгчдийн зан төлөвийн өөрчлөлтөд дасан зохицохгүй байна. Бас хэрэглэгчид ч тансаг бүтээгдэхүүний сонголтыг буруу өнцгөөр харж ирсэн нь цагны салбар орчин үетэйгээ хөл нийлүүлж чадахгүйд хүргэсэн гэдгийг тэрбээр тайлбарлав.

Ялангуяа тансаг зэрэглэлийн цагны тухайд борлуулалт улам багассан. Хятадад өрнөж буй авлига болон татвараас зайлсхийхийг таслан зогсооход чиглэсэн үйл ажиллагаа болон Хонконгийн зах зээлд үүссэн их хэмжээний илүүдэл нь энэ бүхний шалтгаан. Бас үнэтэй, швейцарь, механик цаг нь арвиц хямгач эрин үед хэр зэрэг зөв зүйтэй сонголт болох талаар олон жил маргалдаж буй.

Хамгийн үнэтэй нь л гэхэд 3000 швейцарь франкаас давдаг байсан тансаг цагны үнэ 2016 онд хамгийн ихээр буурсан. Харин эргэн сэргэж итгэл найдвар гэвэл АНУ-ын эдийн засгийн өсөлт, Европын аялал жуулчлалын сэргэлт л байна. Мөн салбарын гүйцэтгэж захирал, шинжээчид швейцарь цагны үйлдвэрлэлийг урт хугацаанд савлууулж мэдэх ухаалаг цагны талаар өөдрөг төсөөлөлтэй байгаа билээ.

Baselworld-ын шоунд Fitbit, Jawbone зэрэг зүүсгэл технологийн үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүн хэрэгжиж байна. Ухаалаг утасны араас зах зээлийг байлдан дагуулж, швейцарь цагны үнэ уруудахад нөлөөлөх хамгийн гол хүч гэж үзэж байсан эдгээр үйлдвэрлэгчийн бүтээл хэрэглэгчдийн хүлээлтэд хүрсэнгүй.

Харин швейцарь цагны хамгийн том, цор ганц зах зээл болон үлдсэн Хонконгод нөөц бууруулах арга хэмжээ амжилттай хэрэгжиж байна. Борлуулалтын түгээлтийн сүлжээг сайжруулахын тулд Richemont Азид TimeVallie гэх multi-brand стратеги буюу бүтээгдэхүүний нэр төрлүүд тус бүрт өөр өөр брэндийн нэр өгч борлуулах аргаар ажиллаж байна. Үүнийг замчлах анхны дэлгүүрээ 2015 онд Наньжинд нээсэн. Дараа нь Токиод бас нэг салбар байгуулсан. Харин ондоо багтаад дахиад гурван дэлгүүр босгохоор төлөвлөжээ.